



СЭЛЭНГЭ АЙМАГ
АЛТАНБУЛАГ СҮМҮН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 09 сарын 20 өдөр

Дугаар A/182

Алтанбула:

Хугацаат цэргийн албаны ээлжит татлага
зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Монгол Улсын Батлан хамгаалах тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.4, аймгийн Засаг даргын 2021 оны А/272 тоот захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.2021 оны хоёрдугаар ээлжийн хугацаат цэргийн албаны татлагыг 10 дугаар сарын 14-ны өдөр Сүхбаатар сумын цэрэг татлагын байранд зохион байгуулсугай.

2.Хоёрдугаар ээлжийн хугацаат цэргийн албаны татлагыг зохион байгуулах ажлын хэсгийг доорх бүрэлдэхүүнтэй зохион байгуулсугай. Үүнд:

Ажлын хэсгийн дарга
Гишүүдэд

Ү.Янжиндулам- ЗДТГ-ын дарга
Д.Амартувшин-ХЭЗ хариуцсан мэргэжилтэн
Б.Баттулга-1 дүгээр багийн Засаг дарга
Г.Жамбалдорж- 3 дугаар багийн Засаг дарга
Б.Болорцэцэг-Архив, бичиг хэргийн эрхлэгч

1.2021 оны 2 дугаар ээлжийн хугацаат цэргийн албаны татлагад 1996 оны 01 дүгээр сарын 01 ний өдрөөс 2003 оны 10 дугаар сарын 16 ний хооронд төрсөн 2 дугаар зэргийн цэргийн бэлтгэл үүрэгтэн залуучуудыг хамруулсугай.

2.Цэрэг татлага зохион байгуулах ажлын хэсгийн гишүүдийн үүргийг тодотгон цэрэг татах үйл ажиллагааг осол, зөрчилгүй зохион байгуулахыг ажлын хэсгийн ахлагч, гишүүдэд үүрэг болгосугай.

3.Холбогдох мэргэжилтэн, албан тушаалтуудад ДААЛГАХ нь:

а.“Цэргийн насны залуучуудын эрүүл мэндийг хамгаалах, боловсролын түвшинг дээшлүүлэх” хөтөлбөрийн хүрээнд 2 дугаар зэргийн цэргийн бэлтгэл үүрэгтэн залуучуудын эрүүл мэндийн урьдчилсан үзлэг шээсний ерөнхий шинжилгээ, элэгний В,С вирус илрүүлэх, ДОХ, тэмбүүгийн шинжилгээ, цусны дэлгэрэнгүй, биохимийн шинжилгээ, коронавирусын халдвартыг илрүүлэх түргэвчилсэн шинжилгээг сумандаа 2021 оны 10 дугаар сарын 04-ноос 10 дугаар сарын 8-ний өдрүүдэд зохион байгуулж ажиллахыг сумын Эрүүл мэндийн төвийн дарга /У.Энхбаямба/-д

б.18-25 насны 2 дугаар зэргийн бэлтгэл үүрэгтэн залуучууд нэг бүрт зарлан дуудах хуудас хүлээлгэн өгөх, эрүүл мэндийн шинжилгээнд хамруулах, иргэний

цахим үнэмлэх, цэргийн үүрэгтний үнэмлэх, гэрийн шаахай, 4-5 зэлжийн амны хаалт, нийгмийн даатгалын дэвтэр, эрүүл мэндийн үзлэгийн анкет, 4 хувь цээж зураг зэрэг холбогдох баримтыг бүрдүүлж цэрэг татлагын байранд заасан хугацаанд бэлэн байлгах, цэрэг татлагын анкетыг 18-25 насны хоёрдугаар зэргийн бэлтгэл үүрэгтэн тус бүрд бүртгэн шивж архивт хулээлгэн өгөхийг багийн Засаг дарга /Г.Жамбалдорж, Б.Баттулга / нарт,

в. Цэрэг татлагын үеэр нийгмийн хэв журмыг сахиулах, аюулгүй байдлыг ханггуулж, осол гэмтлээс урьдчилан сэргийлэх арга хэмжээг авч ажиллахыг сумын хэсгийн төлөөлөгч /Г.Энхтувшин/-д

г.Хугацаат цэргийн албанад татагдагчдыг хүргэхэд шаардагдах тээвэр шатахуун, томилолт, бичиг хэргийн зардлыг холбогдох зардлаас гарган зарцуулахыг сумын Засаг даргын Тамгын газарын нягтлан бодогч /Р.Насанжаргал/-д

4.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж, ажлын тайланг нэгтгэн фото зурагжуулж, баримтжуулан ажиллахыг сумын хууль эрх зүй хариуцсан мэргэжилтэн /Д.Амартувшин/-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

Н.ОТГОНЦОГТ

